

# ӨВЧТӨНИЙ ЭРХ

1. Өвчтөн нь эрүүл мэндийн халамж асрамж авх эрхтэй, энэ үйлчилгээг эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ.
2. Өвчтөн нь эмчлэгч эмчийнхээ болон түүнийг асран сувилж буй бусад мэргэжилтнүүдийн нэрийг мэдэх эрхтэй. Эмнэлгийн байгууллагын бололцоонд тохируулж өөрийн хувийн эрх ашгаа хамгаалах эрхтэй жнь: өдөр бүр гэр бүлийн гишүүд болон найз нөхөдтэйгөө уулзах боломж. Эргэлт ба зочид авахыг ноцтой шалтгааны улмаас хязгаарлаж болно.
3. Өвчтөн нь цаашдын онош тогтоох ба эмчилгээ бүрийн эхэнд эмчлэгч эмчээсээ мэдээлэл авч түүнийг зөвшөөрөх эсэхээ шийдвэрлэх эрхтэй. Гэнэтийн аюул тулгарсан тохиолдолд авах арга хэмжээний үед үүсч болох эрсдлийн тухай зохих мэдээлэл авсан байна. Хэрэв эмчилгээний өөр бусад арга вариант байгаа тохиолдолд түүнтэй танилцах түүний тухай мэдээлэл авах эрхтэй. Мөн түүнд оролцох хүмүүсийн нэрсийг мэдэх эрхтэй.
4. Өвчтөн нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд эмчилгээнээс татгалзах эрхтэй, үүний зэрэгцээ түүнд өөрийн шийдвэрийн улмаас эрүүл мэндэд учрах үр дагаврын тухай мэдээлэл өгнө.
5. Амбулаторийн ба эмнэлгийн шинжилгээ, сувилал, эмчилгээний явцад өвчтөн нь эмчилгээний програмтай холбогдуулж түүний хувийн эрх ашиг, ичингүйрлийг дээд зэргээр харгалзахыг шаардах эрхтэй. Түүнийн өвчний тухай судлах, зөвлөх, эмчилгээ зэрэг нь итгэмжит нууцлаг байна. Шинжилгээнд хамрагдаагүй хүн хажууд байх эсэхийг өвчтөн зөвшөөрөх ёстой, хэрэв эмнэлгийн газар тэр хүнийг өвчтөн өөрөө сонгоогүй бол.
6. Өвчтөн нь түүний эмчилгээний тухай мэдээлэл тэмдэглэгээ итгэмжит нууцлаг гэж үзэх эрхтэй. Өвчтөний тухай мэдээлэл хамгаалалттай ба компьютерт боловсруулалсан тохиолдолд ч.
7. Өвчтөн нь эмнэлгийн байгууллагаас боломжийнхоо хүрээнд түүний өвчний шинж чанарт тохирох асрамж үзүүлэхийг хүсэх эрхтэй. Хэрэв шаардлагатай тохиолдолд өвчтөнийг өөр эмнэлгийн байгууллагт шилжүүлж, хүргүүлнэ. Гэхдээ өвчтөнд урьдчилж үүний шалтгаан, шилжүүлэх нь зайлшгүй хэрэгтэй тухай мэдээлэл, бусад арга боломжийн талаар мэдэгдэнэ. Өвчтөнийг хүлээж авах эмнэлгийн байгууллага эхэлж үүнийг зөвшөөрнө.
8. Өвчтөн нь түүний эмчилгээг тасралтгүй үргэлжлүүлэн хийнэ гэж хүлээх эрхтэй. Урьдчилж ямар эмч нар, ямар эмнэлгийн байгууллага, ямар цагт түүнд үйлчилэхийг мэдэх эрхтэй. Эмнэлгээс гарсны дараа цаашдын эмчилгээний дарааллын тухай түүний эмчид эмнэлгийн зүгээс мэдээлэл өгнө гэж хүлээх эрхтэй.
9. Эмч стандартын бус ба туршилтын эмчилгээ хийхээр шийдсэн тохиолдолд өвчтөн нь энэ тухай ойлгомжтой тодорхой тайлбар хүсэх эрхтэй. Өвчтөний бичгэн зөвшөөрөл нь энэ эмчилгээний эхлэх нөхцөл юм. Өвчтөн нь дуртай үедээ шалтгаангүйгээр туршилт эмчилгээнээс гарч болно, гэхдээ түүний шийдвэрийн улмаас эрүүл мэндэд учрах үр дагаврын тухай мэдээлэл авна.
10. Өвчтөн нь амьдралын эцэст түүнд мэдрэмж бүхий халамж үзүүлэхийг эмнэлгийн ажилтдаас хүлээх эрхтэй, мөрдөгдөж буй хуулинд харшлахгүй бол түүний хүсэлтийг харгалзах.

11. Өвчтөн нь эмчлүүлж буй эрүүл мэндийн байгууллагын дотоод горимтой танилцах эрх үүрэгтэй, (эмнэлгийн дотоод горим). Өвчтөн нь өөрийн данс тооцоогоо шалгах эрхтэй, тооцоог хэн төлж буйгаас үл харгалзан нэгж бүрийг тайлбарлуулах эрхтэй.

Энэхүү Өвчтөний эрх нь 1992 оны 2 сарын 25-аас хүчинтэй.

Этикийн кодекс, Өвчтөний эрхийг санал болгов, сануулгын үйл ажиллагааны дараа БНЧУ-ын Эрүүл мэндийн яамны Төв этикийн комиссоос боловсруулж батлав.